



Оксфордын
уншлагын
мог

Цэцэрлэгт хүрээлэнд



Родерик Хант
Алекс Бричта




Киппер, Чипийн өрөөнд орж шидэт
түлхүүрийг авлаа. Шидэт түлхүүр туяарч
эхлэхэд,

- Өө, туслаарай гэж Киппер хэлэв.



Киппер гүйн гарч ирээд, Биф Чип
хоёрт үзүүлээд,
- Туслаарай, түлхүүр туяарч байна гэв.



Биф Чип хоёр Вильф Вильма хоёртой
элсэн дээр тоглож байв. Киппер:
- Шидэт түлхүүрийг хараач гэв.



Биф Кипперийг зэмлэн,
- Алив бүгдээрээ дотогшоо шидэт
байшин уруу орцгоогоорой гэв.



Гэсэн ч оройтсон байлаа. Шидэт
түлхүүр ажиллаж эхэллээ. Тэд жижгэр-
сээр, жижгэрсээр л байлаа.



Хүүхдүүд өвсөн дунд байхад бүх зүйл маш том харагдан, өвснүүд ширэнгэн ой шиг санагдана.

- Ямар том цэцэг вэ! гэж Киппер хэлж байлаа.




Чип нэг зөгий харжээ. Тэр зөгийнд, бас
ширэнгэнд ч дургүй байсан болохоор,
- Эндээс явцгаая гэж хэлэв.




Хүүхдүүд ширэнгэнээс гарч, уул уруу
явав.

- Ямар өндөр уул вэ? гэж Вильф
хэллээ.




Чип авирч эхлэв. Тэр оройд нь гарахыг
хүсч,
- Нааш ир, авирцгаая гэв.




Уулын оройд гарахад Киппер
халууцжээ.

- Би ууланд авирах дургүй гэхэд
Киппер:

- Өө, үгүй ээ гэв.



Хүүхдүүд доор байх элсийг харав.
- Энэ элсэн цөл шиг харагдаж байна,
бууцгаая гэв.




Вильма:

- Хараач тоглоомон машин байна. Бид үүнийг унаад доош цөл үрүү бууж болно гэв.



Тэд машинд суун доошоо буухад,
- Хөгжилтэй байна гэж Вильма
хэллээ.



Машин элсэнд суун зогсоход хүүхдүүд
буулаа. Гэтэл Вильма:
- Хараач! аварга муур гэв.



Хүүхдүүд шил үрүү зугтаан оров.
Тэгэхэд Киппер маш их айж байлаа.




Муур шилэн доторхийг сонирхон харж, савраараа түлхэв. Хүүхдүүд:

- Яваач, муур аа! гэж хашгиралдаж байлаа.



Гэтэл Флоппи ирж муурны араас хөөв.
Хүүхдүүд ч шилнээс гарлаа. Биф:
- Сайн, том Флоппи гэж хэллээ.



Тэд цөл дундуур алхаж, бүгд халууцаж байв. Киппер:

- Би юм уумаар байна гэв.



Вильф:

- Хараач, аварга гүзээлзгэнэ байна гэв.

Хүүхдүүд гүйлдэн очиж идлээ. Чип:

- Би гүзээлзгэнд дуртай гэхэд Вильф:

- Би ч гэсэн гэлээ.



Хүүхдүүд гүзээлзгэнэ идээд л байв.
Маш их идлээ. Киппер уруулаа долоон,
- Энэ аялал одоо л надад таалагдаж
байна гэв.



Гэтэл бороо орж эхэллээ.

- Ямар том дуслууд вэ? гэж Вильма хэлэв.

- Миний дотор муухайрч байна гэж Кипперийг хэлэхэд, Чип ч гэсэн тэгж хэлэв.



Хүүхдүүд аварга цэцгийн сав уруу
гүйн очиж, түүний доор нуугдлаа. Гэтэл
түлхүүр туяарч эхлэв.



Ид шид дууссан байв. Чип
- Би харж чадахгүй байна гэв. Учир нь
түүний толгойд цэцгийн сав байв.
- Энэ малгай надад таалагдлаа гэж
Вильма хэллээ.



Аав гүээлзгэнээ хараад,
- Бодоод олохгүй юм. Энд аварга
сумнууд байх ёстой доо гэв.



Оксфордын
уншлагын
мог

Шатлал 6
Түүхүүд

Цэцэрлэгт хүрээлэнг

Ид шид дахин эхлэх
үед хүүхдүүд гадаа
тоглож байв.



Хэвлэн нийтлэлийг
Интерпресс ХХК



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй
«Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.